



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/71

Хөхөө

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх сумын төвийн Сагадай, Хөвөн хорооллын зам засварын ажлыг зохион байгуулах, хяналт тавих, хүлээж авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: З.Дашням – Хөхөө багийн Засаг дарга

Гишүүд: Б.Батжаргал- Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Чулуунбаатар – Газрын даамал

Н.Зоригт – Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Х.Насанжаргал-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2. Зам засварын ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч, гишүүд нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ

